

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ

БАГАЧУУД ХҮНС ОРОН НУТГАА ТҮГЭЗЭР
ЗАХИРАЛ **Б.МӨНХНАСАН**

2023 оны 02 дугаар сарын 03

1116116610

**БАГАЧУУД ХҮНС ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2023 ОНД
АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 02 дугаар сарын 03

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв санхүү	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах ажилтан
1	2	3	4	5
Зорилт 1. Ажилчдын цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль, тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох				
1.1	Ажилтнуудын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож хэрэгжүүлэх	20 хувь	Жилдээ	Захирлын зөвлөл
1.2	Ажилчдад олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан тогтоож олгох	-	Жилдээ	Ерөнхий нягтлан
1.3	Алба хаагчдад сар бүр хоол, унааны зардлыг олгох	144000	Жилдээ	Захирлын зөвлөл
1.4	Ар гэрийн гачигдал, шинээр гэр бүл болох, шинээр хүүхэдтэй болоход санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж үзүүлэх	1000000	Жилдээ	Захирлын зөвлөл
1.5	Ажилчдын 0-16 насны хүүхдүүдэд хүүхдийн баярыг тохиолдуулан баяр хүргэж бэлэг өгөх	1800000	Жилдээ	Захирлын зөвлөл
1.6	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг ажилчдад түлээ нүүрс худалдан авахад хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу дэмжлэг үзүүлэх	20 хувь	Жилдээ	Захирлын зөвлөл
1.7	Ажилтны хөдөлмөрийн амжилт, гавъяаг үнэлж, төрийн шагнал, одон медалиар шагнуулах асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах	-	Жилдээ	Захирлын зөвлөл
Зорилт 2. Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл, боломжоор хангах				
2.1	Ажилтнуудын албан хэрэгцээнд зориулж шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, скайнер, хувилагч болон бусад техник хэрэгслээр хангах	18000000	Жилдээ	Захирлын зөвлөл
2.2	Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үед унаагаар хангах	800000	Жилдээ	Захирлын зөвлөл
2.3	Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах тав тухтай орчинг бий болгохын тулд (өрөө тасалгааны агааржуулалт, халаалт, гэрэлтүүлэг, өрөөний тохижилт, цахилгаан хангамжийн үйлчилгээ гэх мэт)	1500000	Жилдээ	Захирлын зөвлөл

2.4	Үйлчилгээний болон түгээлтийн ажиллагсадыг ажлын тусгай хувцас, хамгаалах болон үйлчилгээнд шаардагдах, хэрэгсэл, материалаар хангах	11340000	Жилдээ	ХАБЭА, дотоод хяналтын ажилтан
Зорилт 3. Орон сууцны нөхцөлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад зохих хэмжээний дэмжлэг үзүүлэх				
3.1	Ажилчдын амьдрах нөхцөлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад дотоод журамд заасны дагуу зохих хэмжээний дэмжлэг үзүүлэх	-	Жилдээ	Захирлын зөвлөл
3.2	Ажилчдын орон байрны нөхцөлөө сайжруулах болон амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор банкнаас зээл авахад нь шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх	-	Жилдээ	Архив бичиг хэргийн ажилтан
Зорилт 4. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх				
4.1	Ажилчдыг жилд хоёр удаа эмч нарын үзлэгт хамруулж, шаардлагатай хүмүүст эмчилгээ хийлгэх боломж олгох	1160000	Жилдээ	Эрүүл ахуйч
4.2	Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан ажилтны амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт албан тушаалын 1 жилийн цалинг, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд гэмтлийн зэргээс нь хамаарч тодорхой хувийн эмчилгээний зардлыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгох	-	Жилдээ	Захирлын зөвлөл
4.3	Ажилтны сарын цалингаас илүү төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэх болсон тохиолдолд эмнэлгийн тодорхойлолт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг харгалзан тухайн ажилтны эмчилгээний зардалд албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй мөнгөн тусламж олгож, дэмжлэг үзүүлэх	1-3 сарын цалин	Жилдээ	Захирлын зөвлөл
Зорилт 5. Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах				
5.1	Байгууллагын ажилтнуудын дунд дартс, теннис, шатар, даамны тэмцээн зохион байгуулах	500000	Жилдээ	Менежер, хуульч, хүний нөөц, ХАБЭА, дотоод хяналтын ажилтан
5.2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийг хариуцан ажилладаг дөрвөн байгууллагын дунд жил бүр зохион байгуулагддаг уламжлалт спортын уралдаан, тэмцээнд оролцох	-	Жилдээ	Спорт хамтлаг
5.3	Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.6-д зааснаар ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, зорилгоор сард 1 удаа спорт зааланд чөлөөт тоглолт явуулж байх	1680000	Жилдээ	Спорт хамтлаг

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
МЕНЕЖЕР, ХУУЛЬЧ, ХҮНИЙ НӨӨЦ



Г.ОТГОНЦЭЦЭГ

**БАГАЧУУД ХҮНС ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2023 ОНД
АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Хувь
1	2	3	4
Зорилт 1. Ажилчдын цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг, хууль, тогоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох			
1.1	Ажилтнуудын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож хэрэгжүүлэх	2023 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлагдсантай холбогдуулан ажилчдын албан тушаалын цалинг 25-35 хувиар нэмж олгосон.	100
1.2	Ажилчдад олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан тогтоож олгох	Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан мөрдөн ажиллаж байна.	100
1.3	Алба хаагчдад сар бүр хоол, унааны зардлыг олгох	2023 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлагдсантай холбогдуулан ажилчдын хоол унааны нэмэгдлийг 20 хувиар нэмж олгосон.	100
1.4	Ар гэрийн гачигдал, шинээр гэр бүл болох, шинээр хүүхэдтэй болоход санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж үзүүлэх	Шинээр хүүхэд төрүүлсэн Д.Мөнхцэцэгт 500,000 төгрөг, хүүхдийн сэвлэг үргээхэд зориулж П.Намжилмаад 1,000,000, А.Энхдолгионд 500,000.00 төгрөг, Э.Баярцогтод 500,000.00 төгрөгийг тус тус олгосон.	100
1.5	Ажилчдын 0-16 насны хүүхдүүдэд хүүхдийн баярыг тохиолдуулан баяр хүргэж бэлэг өгөх	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилчдын 0-16 насны 30 хүүхдэд гарын бэлэг өгч, 1,800,000 төгрөгийг зарцуулсан.	100
1.6	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг ажилчдад түлээ нүүрс худалдан авахад хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу дэмжлэг үзүүлэх	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг 8 ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлтийг үзүүлж нийт 2,560,000 төгрөгийг олгосон.	100
1.7	Ажилтны хөдөлмөрийн амжилт, гавъяаг үнэлж, төрийн шагнал, одон медалиар шагнуулах асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах	Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулсан А.Нямжав, Г.Отгонцэцэг нарт хөдөлмөрийн дотоод журамд зааснаар хүндэтгэл үзүүлэхээр төлөвлөж байна.	50
Зорилт 2. Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл, боломжоор хангах			
2.1	Ажилтнуудын албан хэрэгцээнд зориулж шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, сканнер, хувилагч болон бусад техник хэрэгслээр хангах	Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай байсан 2 компьютер, 4 принтерийг нийт 8,919,400 мянган төгрөгөөр шинээр худалдан авч ажилтныг ажиллах нөхцлөөр хангасан.	100
2.2	Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үед унаагаар хангах	Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлага гарсан тохиолдолд тухай бүр нь унааны асуудлыг шийдвэрлэж ажилласан.	100

2.3	Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах тав тухтай орчинг бий болгохын тулд (өрөө тасалгааны агааржуулалт, халаалт, гэрэлтүүлэг, өрөөний тохижилт, цахилгаан хангамжийн үйлчилгээ гэх мэт)	Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулж халаалтыг нэмж, өрөөнүүдийн гэрлийг шинээр сольж, ажиллах таатай нөхцлөөр хангасан.	100
2.4	Үйлчилгээний болон түгээлтийн ажиллагсадыг ажлын тусгай хувцас, хамгаалах болон үйлчилгээнд шаардагдах, хэрэгсэл, материалаар хангах	Түгээлтэнд явж буй ажилчид болон оффисын ажилчдад маск, гар ариутгагчаар бүрэн ханган ажилладаг. Түгээлтийн ажилчдын мах, хуурай хүнсний хувцаст хавар, намар, өвлийн куртик, өмдний хос, хавар, намар, өвлийн гутал хэрэглэлд нийт 2,961,000 төгрөгийг зарцуулсан байна.	100
Зорилт 3. Орон сууцны нөхцөлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад зохих хэмжээний дэмжлэг үзүүлэх			
3.1	Ажилчдын амьдрах нөхцөлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад дотоод журамд заасны дагуу зохих хэмжээний дэмжлэг үзүүлэх	Шинээр орон байранд орсон эрүүл ахуйч Ц.Мөнхтуяад 1,000,000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн.	100
3.2	Ажилчдын орон байрны нөхцөлөө сайжруулах болон амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор банкнаас зээл авахад нь шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх	Амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор 5 ажилтан банкнаас зээл авахад шаардлагатай баримт бичгийг тухай бүр нь гаргаж өгч байсан.	100
Зорилт 4. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх			
4.1	Ажилчдыг жилд хоёр удаа эмч нарын үзлэгт хамруулж, шаардлагатай хүмүүст эмчилгээ хийлгэх боломж олгох	Ажилчдыг Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт 2 удаа хамруулахад 1,194,000 төгрөг, зарцуулсан.	100
4.2	Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан ажилтны амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт албан тушаалын 1 жилийн цалинг, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд гэмтлийн зэргээс нь хамаарч тодорхой хувийн эмчилгээний зардлыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгох	Албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно.	100
4.3	Ажилтны сарын цалингаас илүү төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэх болсон тохиолдолд эмнэлгийн тодорхойлолт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг харгалзан тухайн ажилтны эмчилгээний зардалд албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй мөнгөн тусламж олгож, дэмжлэг үзүүлэх	Ажилчдын дундаас төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэсэн тохиолдол байхгүй болно.	100
Зорилт 5. Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах			
5.1	Байгууллагын ажилтнуудын дунд дартс, теннис, шатар, даамны тэмцээн зохион байгуулах	Байгууллагын ажилчдын дунд дартс, ширээний теннисний тэмцээнийг зохион байгуулсан.	100
5.2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийг хариуцан ажилладаг дөрвөн байгууллагын	"Өсвөр үе" ОНӨААТҮГазар нь жил бүр зохион байгуулагддаг уламжлалт спортын арга хэмжээг зохион байгуулаагүй болно.	100

	дунд жил бүр зохион байгуулагддаг уламжлалт спортын уралдаан, тэмцээнд оролцох		
5.3	Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.6-д зааснаар ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, зорилгоор сард 1 удаа спорт зааланд чөлөөт тоглолт явуулж байх	Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэхийн тулд Сүхбаатар дүүргийн 31, 155 дугаар сургуулийн зааланд сард 1 удаа зааланд тоглож чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлсэн.	100

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
МЕНЕЖЕР, ХУУЛЬЧ, ХҮНИЙ НӨӨЦ



Б.МӨНХНАСАН

Г.ОТГОНЦЭЦЭГ